



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/452

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, 4.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 28 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад онцгой хувь нэмэр оруулж, хөдөлмөр, урлаг, спортын өндөр амжилт, үр бүтээл гарган олон түмэнд хүндлэгдсэн иргэдийг алдаршуулах "Хүндэтгэлийн туг" захиалахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 5,500,000 (таван сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.АМГАЛАНБААТАР



C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001403

Аймгийн Засаг даргын 2022 оны 07
дугаар сарын 20 -ны өдрийн 452 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт
1	Аймгийн туг (хатгамал бичиг, дүрс, код бүхий)	10 ширхэг	550,000	5,500,000
Нийт дүн :				5,500,000

__оОо__